

МОНГОЛ НФТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

САНАМЖ: Энэхүү үйлчилгээний нөхцөл нь “Комплекс Дижитал Экосистем” ХХК-ийн Монгол НФТ платформ /цаашид “Монгол НФТ” гэх/ болон Харилцагч нарын хооронд байгуулагдах үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн нөхцөл болно. Харилцагч www.mongolnft.com сайтад бүртгүүлснээр энэхүү нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдож, талуудын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзэх тул та энэхүү үйлчилгээний нөхцөл болон нууцлалын бодлогод заасан нөхцөлтэй сайтар танилцана уу. Монгол НФТ платформоор дамжуулан хийгдсэн, Монгол НФТ платормоос үл хамаарах аливаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүсэх эрсдэл, үр дагаврыг та өөрөө хариуцахыг анхаарна уу.		
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ		
1. НЭР ТОМЪЁО	✓	Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд: • “Виртуал хөрөнгө / НФТ” гэж Монгол НФТ платформ дээр арилжаалагдаж буй, Бүтээл гаргагчийн бүтээсэн Дижитал арт бүтээлийг; • “Бүтээл гаргагч” гэж Монгол НФТ платформ дээр өөрийн хийсэн бүтээлийг НФТ болгон гаргасан уран бүтээлчийг; • “Монгол НФТ хаяг” гэж www.mongolnft.com цахим хуудас дээр харилцагч өөрийн нэрээр бүртгүүлсэн цахим бүртгэлийг; • “Харилцагч” гэж Монгол НФТ платформд бүртгэл үүсгэж, виртуал хөрөнгийн арилжаанд оролцож буй иргэнийг; • “Хэтэвч” гэж www.mongolnft.com цахим хуудас дах харилцагчийн дансыг; • “Цахим шуудангийн хаяг” гэж Монгол НФТ хаяг дээр бүртгэлтэй и-мэйл хаягийг; • “Идэш хөтөлбөр” гэж “Wolf NFT” цуглуулга эзэмшигчид нийлэн хөрөнгө босгож, дэлхийд алдартай, үнэ ханш нь хурдацтай өсөж буй дижитал хөрөнгийг худалдан авах ба авсан хөрөнгө буюу идэшний үнийн өсөлтөөс ашгаа хуваан авах зарчмыг.
2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ	✓	Монгол НФТ нь Non Fungible Token буюу дахин давтагдахгүй токен гэсэн утгатай блокчэйн протокол юм. Энэхүү протоколыг ашигласнаар та ямар ч бүтээлийг дижитал хэлбэрт оруулан блокчэйн дээр бүртгэлийг үүсгэж өмчлөл болон шилжилтийн мэдээллийг бүртгэн авах боломжтой. Та өөрийн өргөн хэрэглэж буй зураг, дуу, бичлэгүүдийн оригинал эхийг дижитал хэлбэрээр худалдан

		авч өмчлөх, түүнчлэн хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр эргэлтэд оруулах байдлаар ашиглах боломжтой юм. ✓ Энэхүү үйлчилгээний нөхцөл нь Харилцагч (та) болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 509 дугаар тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч”-ээр бүртгэгдсэн “Комплекс Дижитал Экосистем” ХХК нарын хооронд байгуулагдсан ба үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино. ✓ Та үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлогод заасан нөхцөлүүдтэй танилцаж, хүлээн зөвшөөрснөөр “Комплекс Дижитал Экосистем” ХХК -иас үзүүлж буй НФТ үйлчилгээ авах боломжтой. ✓ Бидний үйлчилгээг авахаас өмнө та энэхүү гэрээнд заасан нөхцөлүүдийг сайтар уншиж танилцана уу.
3.	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ	✓ Монгол НФТ нь НФТ буюу виртуал хөрөнгө гэж нэрлэгддэг бүтээгдэхүүн, зураг, дуу хөгжим, хөдөлгөөнт дүрс, бичлэг зэргийг арилжааны хэлбэрээр худалдан авах боломжийг олгодог цахим үйлчилгээний платформ болно. ✓ Бүтээл гаргагч нь өөрийн оюуны өмч болох виртуал хөрөнгийг Монгол НФТ платформоор дамжуулан бусад худалдаалах боломжоор хангагдах бол Харилцагч нь тэдгээрийг эзэмших эрхийн хүрээнд ашиглах боломжоор хангагдана. ✓ Харилцагч нь өөрийн Монгол НФТ хаяг үүсгэж, дараах гүйлгээг хийх боломжтой болно. Үүнд: • Өөрийн хэтэвчний үлдэгдлийн хүрээнд Монгол НФТ платформд нээлттэй арилжаалагдаж буй виртуал хөрөнгөөс худалдан авах, худалдах, стэйкинг хийх, идэш хөтөлбөрт хамрагдах болон Монгол НФТ платформоос хэрэгжүүлж буй бусад үйлчилгээнд хамрагдах; • Өөрийн хэтэвчинд заагдсан дижитал токен, койныг өөрийн Комплекс бирж дэх хэтэвчнээс цэнэглэх; • Өөрийн хэтэвчийг Монгол НФТ платформ дахь боломжит төлбөрийн хэрэгслүүдээр дамжуулан цэнэглэх; • Монгол НФТ платформ дахь өөрийн хэтэвчнээс зарлагын гүйлгээг өөрийн бүртгүүлсэн дансандаа хүлээн авах боломжтой.
4.	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ТАЛ	✓ Хэлцэл зайнаас цахимаар хийгдэнэ. ✓ Харилцагчийн байнга оршин суугаа нутаг дэвсгэр харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлнэ /Холбогдох хууль, тогтоомжоор хориглосон нутаг дэвсгэрээс бусад тохиолдолд/
5.	ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН	✓ “Комплекс Дижитал Экосистем” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 10-ны

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ, ДАВУУ ТАЛ	өдрийн 509 дугаар тогтоолоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч”-ээр бүртгэгдсэн, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээд болно. ✓ “Комплекс Дижитал Экосистем” ХХК-ийн “Монгол НФТ платформ” нь 2021 оны 9 дүгээр сараас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй Монгол улсын ууган НФТ платформын нэг болно. ✓ “Монгол НФТ платформ” нь ISO 27001 мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлсэн. ✓ ДАН танилт, нэвтрэлтийн нэгдсэн системд холбогдсон. ✓ “Монгол НФТ платформ” нь зохицуулалттай үйлчилгээнд хамаарах тул Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагын хяналтын дор үйл ажиллагаагаа эрхэлдэг болно.
6. ХАРИЛЦАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА	✓ Иргэн нь нэвтрэх эрх үүсгэж буй өдрийн байдлаар 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай байх; ✓ Хуулийн этгээд нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэл авч байгаагүй, татан буугдаагүй байх.
7. ХЭРЭГЛЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	✓ Монгол НФТ платформ дах бүртгэлийг зөвхөн өөрийн нэрээр бүртгүүлсэн этгээд ашиглана. ✓ Харилцагч нь Монгол НФТ платформ дах өөрийн Монгол НФТ хаягийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх, нэвтрэх нэр, нууц кодыг бусдад задруулахгүй байх үүрэг хариуцлагыг бүрэн хүлээх ба Монгол НФТ нь Харилцагчийн гүйлгээ болон үйлдэлд сэжигтэй болон хэвийн бус нөхцөл байдал илэрсэн тохиолдолд нэн даруй хаягийг битүүмжлэх, зарлагын гүйлгээг хязгаарлах эрхтэй. Иргэн нь төгрөгийн зарлагын гүйлгээг зөвхөн өөрийн нэр дээрх банкны данс руу шилжүүлэг хийх эрхтэй байна. Хуулийн этгээд нь үйлчилгээ авахдаа зөвхөн тухайн хуулийн этгээдийн нэр дээр данс үүсгэж, холбоно. Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэрээр данс үүсгэхийг хориглоно.
8. ХАРИЛЦАГЧИЙН ЗААВАЛ МЭДВЭЛ ЗОХИХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	✓ Харилцагч нь Монгол НФТ платформд бүртгүүлсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, үүнтэй холбогдуулан гарсан эрсдэл, хариуцлагыг бүрэн хүлээнэ. ✓ Монгол НФТ үйлчилгээ нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан зохицуулалттай үйлчилгээ тул Харилцагч та Монгол НФТ платформын зүгээс холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шаардаж буй аливаа баримт, мэдээллийг Монгол НФТ платформд гаргаж өгөх үүрэгтэйг анхаарна уу.

	✓ Хэрэв та гадаад улсаас хандаж байгаа бол таны оршин сууж буй улсын хууль тогтоомжоор криптовалют, дижитал бүтээлийн арилжаа, гүйлгээг хориглодог эсэхийг сайтар шалгасны үндсэн дээр хандана уу! ✓ Таны байршлаас шалтгаалан үйлчилгээ үзүүлэх, данс цэнэглэх явцад хязгаарлалт, саад, бэрхшээл учирч болзошгүй болохыг анхаарна уу! ✓ Өөрийн нэвтрэх эрх, дансны аюулгүй байдлаа хамгаалахын тулд дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд: • Нэвтрэх эрхийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор өөрийн Монгол НФТ хаяггийг гар утас, таблет, суурин эсхүл зөөврийн компьютер зэрэг олон төхөөрөмжөөс хандахгүй байх; • Дээрх төхөөрөмжүүдээс нэвтрэхдээ нэвтрэх хаяг, нууц үгээ сануулахгүй байх; • Харилцагч нь платформд нэвтрэхдээ Two Factor Authentication буюу 2 шатлалт баталгаажуулалт хийх; ✓ Монгол НФТ-ийн буруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд үүсч болох харилцагчийн хийсэн шилжүүлэг, захиалгын үр дагавар эрсдэлийг зөвхөн та өөрөө хариуцахыг анхаарна уу ✓ Монгол НФТ гаргаж байгаа бүтээгдэхүүн болон мэдэгдлүүд нь санхүүгийн болон хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш тул өөрийн буруугаас алдагдалд орсон, буруу гүйлгээ хийж хөрөнгөө алдах, алдагдалд хүрэх зэрэг хохирлуудыг Харилцагч өөрөө хариуцах болохыг анхаарна уу. ✓ Бид зах зээлд “Тухайн нөхцөл байдал” болон “Арилжаалагдах боломжтой” нөхцөлөөр үйлчилгээ үзүүлнэ. ✓ Бүтээл гаргагч буюу уран бүтээлч нь НФТ-ээр дамжуулан илэрхийлж буй бүтээгдэхүүн, зураг, дуу хөгжим, хөдөлгөөнт дүрс, бичлэг, үйлчилгээ зэргийн найдвартай, хууль ёсны байдлыг бүрэн хариуцдаг тул та аливаа НФТ авахаас өмнө эрсдэл, шийдвэрийн үндэслэл, эрх зүйн байдал зэргийг анхааралтай судлахыг зөвлөж байна.
9. МОНГОЛ НФТ-ийн ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ НӨХЦӨЛ	✓ Монгол НФТ нь Харилцагчийн бүртгүүлсэн мэдээллийн үнэн зөв байдлыг хадгалах боловч агуулгын таарамж, үнэн бодит, найдвартай, бүрэн бүтэн байдлын хувьд баталгаа гаргахгүй. Өөрөөр хэлбэл мэдээллийн агуулгаас шууд болон шууд бусаар үүдэн гарсан аливаа хохирлыг хариуцахгүй болно. ✓ Бүтээл гаргагчийн Монгол НФТ платформд байршуулсан мэдээллийг түүнээс бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу өөрчилж болно. ✓ Харилцагч нь энэхүү үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч бүртгэл хийлгэснээр хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан, эсхүл Харилцагчийн үйлчилгээ

	авах нөхцөлийг хангах зорилгоор Харилцагч нь Монгол НФТ-д хувийн мэдээллээ ашиглуулах, гуравдагч этгээдэд дамжуулахыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. ✓ Хөрөнгө оруулалтын талаар зөвлөгөө өгөхгүй ба өөрийн вэб сайтад байршуулсан болон бусад мэдээллийн хэрэгслээр явж буй мэдээлэл, тайлбарт хариуцлага хүлээхгүй. ✓ Монгол НФТ нь бүтээл гаргагч, Харилцагчийг платформ, вэбийн тасралтгүй, хэвийн ажиллагааны нөхцөлийг ханган ажиллана. ✓ Техникийн улмаас платформ, вэб түр зогсох, засвар үйлчилгээ хийгдэх үед мэдэгдэл гаргаж, олон нийтэд хүргэнэ. ✓ Монгол НФТ нь давагдашгүй хүчин зүйл, хакердах оролдлого, террорист халдлага болон бусад урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас үүссэн аливаа хохиролд хариуцлага хүлээхгүй. ✓ Монгол НФТ нь өөрийн платформ, вэб хуудсаар дамжуулан хийгдсэн хэвийн бус, сэжигтэй арилжааг өөрийн санаачилгаар Харилцагчаас тодруулга авах, эрх бүхий зохицуулагч байгууллагад мэдээллэх эрхтэй. ✓ Монгол НФТ нь аливаа Харилцагч буюу тухайн Харилцагчийн нэгдмэл сонирхолтой этгээдэд Монгол НФТ хаяг нээх болон нэг Харилцагч хэд хэдэн удаа бүртгэл үүсгэн олон Монгол НФТ хаяг нээлгэхийг хязгаарлах эрхтэй. ✓ НФТ нь бүтээл гаргагч, эсхүл НФТ эзэмшигчийн өмч бөгөөд Монгол НФТ платформоор дамжуулан арилжаалагдаж буй аливаа НФТ-тэй холбоотойгоор түүний зохиогчийн эрх, оюуны өмч, зар сурталчилгааны тухай хууль, өрсөлдөөний тухай хууль, тэдгээртэй холбогдон гарах аливаа үүрэгт хариуцлага хүлээхгүй.
10. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ ХАСАХ	✓ Монгол НФТ нь дараах тохиолдолд бүтээл гаргагчийн виртуал хөрөнгө буюу НФТ-ийг Монгол НФТ платформын арилжаа болон хэтэвчнээс хасаж болно. Үүнд: • “Комплекс Дижитал Экосистем” ХХК-аас бүтээл гаргагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу виртуал хөрөнгө буюу НФТ-ийг хасах шаардлагатай болсон; • Бүтээл гаргагчийн НФТ-ийг Монгол НФТ платформын арилжаанаас хасахыг эрх бүхий этгээд шаардсан; • Бүтээл гаргагчийн Монгол НФТ платформоор худалдаж буй виртуал хөрөнгө буюу НФТ нь оюуны өмчийн эрхийн зөрчилтэй нь тогтоогдсон.

	✓ Виртуал хөрөнгө хассантай холбоотой аливаа хохирлыг “Комплекс Дижитал Экосистем” ХХК буюу Монгол НФТ платформ хариуцахгүй болно. ✓ Харилцагч нь бүтээлтэй холбоотой өөрт учирсан хохирлоо амлалтаа биелүүлээгүй буюу буруутай бүтээл гаргагчаас шаардах эрх нээлттэй болно ✓ Мөн криптовалютын зах зээл, гадаад хүчин зүйлээс шалтгаалан Монгол НФТ платформын арилжаанд ашиглагдаж буй токен, койныг Монгол НФТ платформын арилжаа болон хэтэвчнээс хасах боломжтойг анхаарна уу. ✓ Монгол НФТ нь Виртуал хөрөнгийг хасах шийдвэрийг Харилцагч нарт олон нийтийн сүлжээ болон харилцагчийн албан ёсны бүртгэлтэй цахим шуудангаар мэдэгдэнэ. ✓ Дээрх мэдэгдэлд Харилцагчдад виртуал хөрөнгийг Монгол НФТ платформуос бусад хүлээн авагчид шилжүүлэх хугацаа тогтоох ба Харилцагч тухайн хугацаанд багтаан тухайн виртуал хөрөнгийн шилжүүлгийг хийнэ. ✓ Харилцагч нь Монгол НФТ-ээс мэдэгдсэн хугацаанд виртуал хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд Комплекс Дижитал Экосистем ХХК буюу Монгол НФТ аливаа хариуцлага хүлээхгүй.
11. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ	✓ Харилцагч нь Монгол НФТ платформд бүртгүүлснээр дор дурдсан эрсдэлийн хүчин зүйлсийг уншиж танилцан, хүлээн зөвшөөрсөн бөгөөд эрсдэлээс үүдэх бүхий л хохирлыг Компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан зэргээс шаардах эрхгүй болохыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. 1. Эрх зүйн орчноос хамааралтай эрсдэл (a) Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, виртуал хөрөнгийн арилжаа болон шилжүүлэг зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичигт Монгол Улсын хууль тогтоох эрх бүхий байгууллагаас эсхүл Олон Улсын байгууллагаас өөрчлөлт оруулсан эсхүл шинээр эрх зүйн баримт бичиг баталж, дагаж мөрдөж эхэлсэн нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, виртуал хөрөнгө буюу дижитал бүтээлийн үнэлгээ, ханш зэрэгт эерэгээр эсхүл сөргөөр нөлөөлөх боломжтой болохыг; (b) Виртуал хөрөнгө нь аливаа улсын эсхүл Монгол Улсын Засгийн газар, Төв банкаар баталгаажсан буюу төрөөс хүлээн зөвшөөрсөн хууль ёсны мөнгөн тэмдэгт хамаарахгүй, мөн түүнчлэн хадгаламжийн даатгал эсхүл хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамрагдаагүй тул Харилцагчид учирсан санхүүгийн хохирлыг аливаа этгээд нөхөн төлөхгүй болохыг; (c) Монгол улсын хууль тогтоох эрх бүхий байгууллагаас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдсан шаардлагыг биелүүлэх зорилгоор түр хугацаанд үйл

	ажиллагааг зогсоох, эсхүл хууль тогтоомжоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагаас Монгол НФТ платформоор анхдагч болон хоёрдогч зах зээлээр арилжаалагдаж буй виртуал хөрөнгийг, эсхүл түүнийг худалдан авч буй дижитал токен, койн, аливаа криптовалютыг хууль бусад тооцох зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан Монгол НФТ платформын үйлчилгээ доголдох буюу бүр цаашлаад зогсох боломжтой болохыг; (d) Дээр дурдсанаар хязгаарлагдахгүйгээр Монгол Улсын болон Олон Улсын виртуал хөрөнгө, эсхүл виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд шууд хамааралгүй ямарваа нэгэн эрх зүйн баримт бичиг нь виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд нөлөөлөх бүрэн боломжтой болохыг. 2. Гүйлгээ болон шилжүүлгийн эрсдэл (a) Харилцагчийн хийсэн алдаатай /гүйлгээний дүн, хүлээн авах хаяг, хүлээн авагчийн сүлжээ зэргийг буруу бичих/ гүйлгээ нь буцаагдах, мөн түүнээс үүдсэн санхүүгийн хохирол нь нөхөн төлөгдөх боломжгүйг болохыг; (b) Виртуал хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээ хийгдсэн хугацаанаас үл хамааран бүртгэлийн системд бүртгэгдсэн хугацаагаар гүйлгээ хийгдсэнд тооцогдохыг; 3. Зах зээлийн ханшийн хэлбэлзлээс үүдэх эрсдэл (a) Виртуал хөрөнгө нь төрөөс хүлээн зөвшөөрсөн төлбөр тооцоо хэрэгсэл биш тул ямарваа нэгэн төрийн эрх бүхий байгууллагын хяналтад хамаарахгүй учраас өндөр эрсдэлтэйд тооцогдох бөгөөд арилжаанд буй виртуал хөрөнгө, дижитал бүтээлийн үнэ цэнэ, зах зээлийн ханш нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан хэлбэлзэх, эсхүл зах зээлийн үнэ цэнээ бүр мөсөн алдах, үүнээс үүдэн Харилцагч санхүүгийн хохирол хүлээх эрсдэлтэйг Харилцагч ойлгосны үндсэн дээр арилжаанд оролцож байна. 4. Блокчэйн ба программ хангамжийн эрсдэл (a) Монгол НФТ нь өөрийн платформын үндсэн програм хангамж, сүлжээ, систем, сервер зэргийн аюулгүйн ажиллагааг хангах, гадны халдлагаас сэргийлэх зорилгоор өөрийн боломжит хэмжээнд хөгжүүлэлт, засвар, шинэчлэлийг хийх ба Харилцагч нь Монгол НФТ платформын блокчэйн, програм хангамжтай холбоотойгоор дараах эрсдэл үүсч болохыг хүлээн зөвшөөрсөн болно. (b) Монгол НФТ нь өөрийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор програмын шинэчлэлт, хөгжүүлэлт, засвар хийх бөгөөд энэ нь Монгол НФТ-ийг гадны аливаа халдлагаас бүрэн хамгаалагдсан гэж тооцох баталгаа болохгүй болохыг; (c) Монгол НФТ нь платформыг хөгжүүлэх технологийн шинэчлэл, засвар зэргийг бие даан хийх бөгөөд засвар, шинэчлэлийн үед платформын сервер доголдох боломжтойг Харилцагч хүлээн зөвшөөрсөн болно. Монгол
--	---

	НФТ нь өөрөөс болон өөрөөс үл хамаарах шалтгаанаар технологийн хүндрэл үүсч болох бөгөөд үүний улмаас Харилцагч өөрийн хөрөнгийг захиран зарцуулах боломжгүй болох, гүйлгээ саатах, сервер доголдох, арилжааны аливаа захиалга биелэгдэхгүй байх зэрэг (үүгээр хязгаарлагдахгүйгээр бусад) хүндрэл үүсч болохыг. 5. Аюулгүй байдлын эрсдэл (a) Монгол НФТ нь аливаа халдлагад өртсөний улмаас Харилцагчийн гүйлгээ саатах, мэдээлэл алдагдах, виртуал хөрөнгө алга болох, өөр бусад руу шилжих зэргээс үүдэн Харилцагч хохирох; (b) Харилцагч өөрийн хувийн мэдээлэл эсхүл интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, банкны идэвхтэй карт, Монгол НФТ платформд бүртгэлтэй хаягийн нэвтрэх нэр, нууц зэргийг хамгаалах зорилгоор SMS-OTP, 2FA зэрэг давхар баталгаажуулалтын систем (үүгээр хязгаарлагдахгүйгээр бусад) зэргийг ашиглах бөгөөд дээрх мэдээллүүдийг алдсанаас үүдэлтэйгээр ямарваа нэгэн хохирол хүлээх, Харилцагчийн Монгол НФТ платформд бүртгэлтэй хаяг нь гэмт хэргийн зорилгоор ашиглагдаж болзошгүйг болохыг; 6. Хохирол нөхөн барагдуулах боломжгүй байдал (a) Харилцагч нь Монгол НФТ платформд бүртгүүлэн виртуал хөрөнгө худалдан авах, зарахдаа бүтээл гаргагчийн үйл ажиллагаа, зах зээлийн үнэлгээ, технологи, үйлчилгээний аюулгүй байдлын үнэлгээг өөрөө бие даан шинжлэн судлах, анализ хийх чадвартай болохыг илэрхийлнэ. Үүнээс гадна Харилцагч нь энэхүү Үйлчилгээний нөхцөлд дурдсанаас бусад виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой бүхий л эрсдэлийг бүрэн ойлгосны үндсэн дээр үйлчилгээ авч буй тул өөрт учирсан аливаа хохирлыг Монгол НФТ-ээр барагдуулах боломжгүйг хүлээн зөвшөөрсөн болно.
МОНГОЛ НФТ ПЛАТФОРМД ХАЯГ БҮРТГҮҮЛЭХ БА ТАВИГДАХ ШААРДЛАГА	
12. БҮРТГЭЛ	✓ Вэб сайт ашиглахын тулд та www.mongolnft.com хаягаар нэвтрэх (Монгол НФТ хаяг) шинээр бүртгүүлнэ. ✓ Нэр болон цахим шуудангийн хаяг, нууц үгээ оруулах ба үйлчилгээний нөхцөл, нууцлалын бодлого, зөвшөөрлийн маягтуудыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой. ✓ Тодорхой нөхцөлөөс хамаарч бид Харилцагчийг бүртгэх, хэтэвч нээхээс татгалзах эрхтэй.
13. ХАРИЛЦАГЧИЙГ БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ	Монгол НФТ-ийн зүгээс дараах нөхцөл байдалд үндэслэн Харилцагчийн хүсэлтийг цуцлах, Монгол НФТ хаяг нээхгүй байх бүрэн эрхтэй. Үүнд: ✓ Шаардлагатай баримт материалыг дутуу бүрдүүлсэн; ✓ Харилцагч хувийн хэргийг бүрдүүлж өгөхөөс татгалзсан, комплаенсийн хүрээнд шаардлагатай баримт материалыг бүрдүүлж өгөхгүй байх; ✓ Харилцагчийн баримт бичгийн хүчинтэй хугацаа дууссан;

	✓ Насанд хүрээгүй буюу тухайн өдрийн бүртгэлээр 0-18 насны иргэн байх; ✓ Харилцагчийн бүрдүүлж өгсөн баримт материал хуурамч, эргэлзээтэй; ✓ Олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад бүртгэлтэй; ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байх магадлалтай (сөрөг мэдээлэл илэрсэн); ✓ Авлига, хээл хахууль, залилан хийсэн талаарх мэдээлэл баталгаажсан; ✓ Бусад.
14. ХАРИЛЦАГЧИЙН НЭР БАТАЛГААЖУУЛАХ	✓ Монгол НФТ веб сайтад өөрийн бүтээлийг байршуулах, бүртгүүлэх, бүтээл худалдан авахын тулд өөрийн гэсэн Монгол НФТ хаяг нээх шаардлагатай ба ингэснээр хувийн мэдээллээ өгөхийг зөвшөөрсөнд тооцно. Энэхүү мэдээлэл нь таны оюуны өмчийн бүтээлийг хамгаалах, оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг илрүүлэхэд ашиглагдана. ✓ Бид таныг хэн болохыг баталгаажуулах, эдийн засаг, оюуны өмчийн гэмт хэргээс сэргийлэхийн тулд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан танаас лавлагаа авах эрхтэй болно. ✓ Харилцагчийн хэн болохыг баталгаажуулахын тулд бид дараах мэдээллүүдийг авах ба мөн үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд : • Иргэний үнэмлэх (урд, ард талын зураг); • Харилцагчийн селфи зураг; • Харилцагчийн нэр; • Цахим шуудангийн хаяг; • Холбоо барих мэдээлэл; • Утасны дугаар ✓ Та шаардлагатай мэдээллийг өгснөөр бид таныг тухайн мэдээллийг үнэн зөв болохыг баталсанд тооцно. ✓ Бүртгүүлсний дараа эдгээр мэдээлэл нь шинэчлэгдсэн тохиолдолд тухай бүрд нь баталгаажуулах ёстой. ✓ Монгол НФТ таны ирүүлсэн мэдээллийг алдаатай, хуурамч, хуучирсан, бүрэн бус байна гэж үзвэл залруулахыг танаас шаардах бөгөөд заасан хугацаанд залруулаагүй бол Монгол НФТ нь шаардлагатай тохиолдолд үйлчилгээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцлах эрхтэй байна. ✓ Таны өгсөн холбоо барих мэдээллийн дагуу тантай холбогдож чадаагүйн улмаас таны уран бүтээл, оюуны өмчид ямар нэгэн хохирол учирвал холбогдох бүх хариуцлагыг та өөрөө бүрэн хариуцна. ✓ Монгол НФТ хаягийг таны нэрээр өөр бусад гуравдагч этгээд ашиглан, ашиг олох, бусдын оюуны өмчид халдах замаар хэрэглэж байгаа нь тогтоогдвол харилцагчийн Монгол НФТ хаягийг түр хугацаанд түдгэлзүүлэх, Монгол НФТ хаягийг хаах арга хэмжээ авна. Дээрх тохиолдол үүссэн нөхцөлд Монгол НФТ хуулийн хариуцлага хүлээхгүй.

15. КҮС БҮРТГЭЛ БАТАЛГААЖУУЛА Х	✓ ✓ ✓ Та КҮС бүртгэл баталгаажуулалт хийснээр Монгол НФТ дэх өөрийн хэтэвчээсээ зарлага хийх боломжтой болно. Та өөрийн овог, нэр, регистрийн дугаар, хаягийн мэдээллийн баталгаажуулалтыг Дан танилт нэвтрэлтийн системээр дамжуулан хийнэ. Таныг мөн эсэхийг нотлохын тулд дараах боломжит аргуудыг ашиглана.Үүнд: ○ Иргэний үнэмлэхийн урд болон ард талын зураг ○ Иргэний үнэмлэхээ барьж авхуулсан зураг ○ Бусад тусгай программ
16. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ	✓ ✓ ✓ ✓ ✓ Монгол НФТ нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлох үүрэг хүлээдэг. Эцсийн өмчлөгчийг дараах байдлаар тодорхойлно. Хуулийн этгээд: • Хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хувь хүнийг; • Хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хувь хүнийг; • Хуулийн этгээдийг болон хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж, үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хувь хүнийг; • Хуулийн этгээдийн хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр нийт хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээдийг тус тус эцсийн өмчлөгчөөр тодорхойлно. Хуулийн этгээд нь хуулийн этгээдийн дүрэм, гэрчилгээ зэрэг баримт бичгийг бүрдүүлэн өгөх бөгөөд эцсийн өмчлөгчийг тодорхойлох маягыг бөглөж өгнө. Хувь хүн: • Тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хувь хүнийг; • Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн өөрийн хөрөнгийг бусдаар итгэмжлэн удирдуулж, үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тус тус тодорхойлно.
17. ХЭРЭГЛЭЭГ ХОРИГЛОХ	✓ ✓ ✓ Монгол НФТ үйлчилгээнд нэвтэрч, ашигласнаар та худалдааны, эдийн засгийн болон бусад хориг арга хэмжээний жагсаалтад байхгүй гэдгийг зөвшөөрсөнд тооцно. Монгол НФТ нь үйл ажиллагаа эрхлэх зах зээлээ сонгох, зарим улс орнуудад үйлчилгээ үзүүлэхийг хориглох, хязгаарлах эрхтэй. Энэхүү гэрээ нь Харилцагчдийн оршин сууж буй улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Монгол НФТ нь хориглогдсон Харилцагчдыг үйлчилгээнд нэвтрэх, ашиглахыг нь хязгаарлах байр сууриа хатуу хадгална.

18. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	✓ Үйлчилгээний нөхцөлд Монгол НФТ нь хэзээд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй. ✓ Шинэчлэгдсэн нөхцөлийг тухай бүрт нь харилцагчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар хүргүүлнэ. ✓ Шинэчлэгдсэн нөхцөлийг Харилцагч эс зөвшөөрвөл шинэчлэгдсэн нөхцөл хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнө Монгол НФТ-д цахим шуудангаар санал, хүсэлт ээ илгээж болно. ✓ Шинэчлэгдсэн нөхцөл хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхэд Харилцагчаас аливаа хүсэлт ирээгүй тохиолдолд шинэчлэгдсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
19. АЮУЛГҮЙ БАЙДАЛ	✓ Монгол НФТ нь Харилцагчийнхаа оюуны бүтээлийг вэб сайтад байршуулж аюулгүй байдлыг хангахын тулд ISO 27001 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын стандартыг энэхүү платформдоо нэвтрүүлсэн болно. ✓ Харилцагчийн өөрийн үйлдлээс үүсэх эрсдэлүүд болох өөрийн хаяг, хувийн мэдээллийг бусдад алдахаас хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарна уу. ✓ Та өөрийн Монгол НФТ хаяг болон нууц үгийг хадгалж, хамгаалах үүрэгтэй бөгөөд цахим шуудангийн хаяг, нууц үгтэй холбоотой бүхий л үйлдэлдээ дангаар хариуцлага хүлээнэ. Тухайлбал мэдээллээ задруулах, өөрийн оюуны өмчийг алдах, бусдын оюуны өмч бүтээлд хууль бусаар халдах, веб сайт дээр дарснаар байршуулсан янз бүрийн гэрээ журмыг зөвшөөрөх, гэрээний онлайн шинэчлэлт гэх мэт хамаарах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. ✓ Монгол НФТ хаягийг таны нэрээр өөр бусад гуравдагч этгээд ашиглан, ашиг олох, бусдын оюуны өмчид халдах замаар хэрэглэж байгаа нь тогтоогдвол Монгол НФТ-ийн зүгээс хаягийг түр хугацаанд түдгэлзүүлэх, цахим хаягийг хаах арга хэмжээ авна. Дээрх тохиолдолд үүссэн нөхцөлд Монгол НФТ хуулийн хариуцлага хүлээхгүй. ✓ Та дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрнө. Үүнд: 1. Хэн нэгэн этгээд зөвшөөрөлгүйгээр таны Монгол НФТ хаяг болон нууц үгийг ашиглаж байгааг эсвэл аюулгүй байдлыг зөрчсөн бусад үйлдлийг олж мэдвэл тэр даруй Монгол НФТ-д мэдэгдэнэ. 2. Та веб сайт болон үйлчилгээний аюулгүй байдал, нэвтрэлт танилт, бүтээлийн худалдаа, бүтээл байршуулах журмыг дагаж мөрдөнө. 3. Та Монгол НФТ сайтад хандах бүрдээ, үйлчлүүлж дуусмагц системээс гарна. ✓ Та дээрх аюулгүй байдлыг хангаагүйн улмаас учирсан аливаа хохирлыг Монгол НФТ хариуцахгүй.
20. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ	✓ Монгол НФТ нь аливаа асуудал, маргааныг өөрийн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. Зарим асуудлууд нь бусдын эрх зөрчигдөх, хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчих, хэвийн

		бус арилжаа болон үйлчилгээний нөхцөлд тодорхой дурдаагүй бусад асуудлууд багтана. Маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад гарах зардлыг бүхэлд нь Харилцагч хариуцахаар тохиролцов.
21. ҮЙЛЧИЛГЭЭГ АШИГЛАХ ЗААВАРЧИЛГАА	✓	Харилцагч та Монгол НФТ-ийн үйлчилгээг ашиглахдаа дараах нөхцөлийг дагаж мөрдөнө. Үүнд: 1. Монгол НФТ-ийн үйлчилгээг ашиглахдаа, хууль тогтоомж, дүрэм журам, зааварчилгааг дагаж мөрдөх; 2. Олон нийтийн ашиг сонирхол, ёс зүй, бусдын хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх; 3. Төлөх ёстой татвар, хураамжаас зайлсхийхгүй байх болон энэхүү гэрээ, холбогдох дүрэм журмыг зөрчихгүй байх; 4. Виртуал хөрөнгийг хууль бусаар бусдад түгээх, дуурайлган хийх, ашиглах, өөрийн хаягийг бусдад дамжуулан хэрэглүүлэхгүй байх. ✓ Дээрх нөхцөлүүдийг зөрчсөнөөс үүсэх аливаа эрх зүйн үр дагаврыг Харилцагч өөрөө дангаар хариуцах бөгөөд тухайн зөрчлийн улмаас бусдын оюуны өмч, Монгол НФТ-д учруулсан бүх хохирол, зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. ✓ Монгол НФТ-ээс урьдчилж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр вэб сайтад байршуулсан аливаа мэдээллийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно. Харилцагч нь вэб сайтыг Үйлчилгээний нөхцөл болон Нууцлалын бодлогод заасны дагуу Монгол НФТ-ийн хэвийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүйгээр эсвэл шударга бус өрсөлдөөний үйлдэл хийхгүйгээр ашиглана. Хориглогдох үйлдэл нь дор дурдсан зүйлсээр зөвхөн хязгаарлагдахгүй болно. Үүнд: 1. Монгол НФТ-д хуурамч мэдээлэл эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх; 2. Бусдын хаягаар нэвтрэх болон нэвтрэхийг оролдох; 3. Веб сайтын үйл ажиллагааг доголдуулах программ, тоног төхөөрөмж ашиглах, тэдгээрийг хөгжүүлэх; 4. Хуурамч бараа бүтээгдэхүүн үүсгэх; 5. Бусдын оюуны өмчийг дуурайлгах, Харилцагчийг төөрөгдөлд оруулсан бүтээгдэхүүн нийтлэх; 6. Мэдээллийн хүсэлтийг хэт их өгч, сүлжээний ачааллыг хэтрүүлэх; 7. Бидний ашиглаж буй контент шүүлт хийх аргуудыг алгасахыг оролдох; 8. Манай үйлчилгээнээс цуглуулсан өгөгдлийг ашиглан хувь хүмүүс, компаниуд эсвэл бусад хүн, аж ахуйн нэгжүүдтэй холбоо барих;

	9. Манай үйлчилгээнээс цуглуулсан өгөгдлийг ашиглан шууд маркетингийн аливаа үйл ажиллагаанд ашиглах. ✓ Дээрх зөрчлийг гаргасан тохиолдолд Монгол НФТ нь Харилцагчаас зөвшөөрөл авахгүй мөн урьдчилан мэдэгдэхгүйгээр дараах арга хэмжээг авах эрхтэй гэдгийг та хүлээн зөвшөөрнө. Мөн зөвхөн дараах арга хэмжээгээр хязгаарлагдахгүй. Үүнд: 1. Бүтээгдэхүүн нийтлэх эрхийг хаах, түдгэлзүүлэх; 2. Монгол НФТ хаягийг идэвхгүй болгох; 3. Эрх бүхий байгууллагад мэдээлэх; 4. Зөрчлийн талаар болон авсан арга хэмжээний талаар хэвлэн нийтлэх; 5. Зөрчилтэй холбоотой таны нийтэлсэн аливаа мэдээллийг устгах. ✓ Хэрэв Харилцагчийн буруутай үйлдлээс шалтгаалан бусад Харилцагч, гуравдагч этгээд, бүтээл гаргагчид хохирол учирвал бүх хохирлыг буруутай Харилцагч дангаар хариуцна. Мөн үүний улмаас Монгол НФТ-д хохирол, торгууль, нэмэлт зардлыг нөхөн төлж, Монгол НФТ-ийг хохиролгүй болгоно. ✓ Хэрэв Харилцагчийн гаргасан зөрчлөөс үүдэн аливаа этгээд нөхөн төлбөр нэхэмжилсэн, эсвэл захиргааны байгууллагаас хариуцлага ногдуулсны улмаас Монгол НФТ-д хохирол учирсан тохиолдолд тухайн бүх хохирол, зардлыг зөрчил гаргасан Харилцагч нөхөн төлөх ба үүнд өмгөөлөгчийн зардал багтана.
22. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ	✓ Монгол НФТ-ын үйлчилгээг ашигладаг бүтээл гаргагч, Харилцагчдаас үйлчилгээний хураамж, шимтгэлийг авах эрхтэй байна. ✓ Үйлчилгээний хураамжийг “Комплекс Дижитал Экосистем” ХХК нь бие даан тогтоох бүрэн эрхтэй. ✓ “Комплекс Дижитал Экосистем” ХХК нь үйлчилгээний хураамжийг Монгол НФТ платформоор дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ. ✓ Үйлчилгээний хураамжид орох өөрчлөлтийг мэдэгдсэнээс хойш мэдэгдэлд заасан хугацаанаас эхлэн хэрэгжүүлж эхэлнэ. ✓ Харилцагч үйлчилгээний хураамжид орсон өөрчлөлтийг үл зөвшөөрсөн нөхцөлд Монгол НФТ платформын хэтэвчнээс өөрийн хөрөнгөө татаж, өөрийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаас үйлчилгээ цуцлуулах тухай хүсэлтийг цахим шуудангаар илгээх боломжтой. Энэ нөхцөлд бид таны хүсэлтийн дагуу үйлчилгээг цуцална. ✓ Та мэдэгдсэн хугацаанд бидэнд үл зөвшөөрсөн хүсэлтээ цахим шуудангаар ирүүлээгүй нөхцөлд бид таныг үйлчилгээний хураамжид орсон өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

	✓ Харилцагч нь Монгол НФТ-ээс мэдэгдсэн хугацаанд виртуал хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд Монгол НФТ болон виртуал хөрөнгө гаргагч аливаа хариуцлага хүлээхгүй.
23. ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААРЛАЛТ	✓ Монгол НФТ нь дараах тохиолдолд Харилцагч танд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй гэдгийг та хүлээн зөвшөөрөх ба зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Үүнд: 1. Гуравдагч этгээд таны зөвшөөрөлгүйгээр таны Монгол НФТ хаягийг ашиглах; 2. Монгол НФТ-ний үйлчилгээг ашиглах эсвэл ашиглахгүй байх; 3. Гуравдагч этгээд таны оюуны бүтээлд халдах, тэдгээрийг хуулбарлах; 4. Монгол НФТ-д шууд хамааралгүй, Монгол НФТ-ийн үйлчилгээтэй холбоотой бусад алдагдал. ✓ Бид сүлжээний ердийн засвар үйлчилгээ болон цахилгаан тасрах, байгалийн гамшиг, үйлчилгээ үзүүлэгч талын асуудлууд, засгийн газрын үйл ажиллагаа зэрэг гаднын хүчин зүйлээс шалтгаалсан үйлчилгээний доголдол, сааталд хариуцлага хүлээхгүй. ✓ Хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсан Харилцагч хоорондын тохиролцоонд Монгол НФТ хариуцлага хүлээхгүй. ✓ Энэхүү гэрээний дагуу хийгдсэн аливаа худалдан авалт, үйлчилгээ, хөгжүүлэгч материал, болон гэрээгээр олгосон бусад зүйлстэй холбоотойгоор ямар ч тохиолдолд Монгол НФТ, түүний салбар компаниуд, тэдний хувьцаа эзэмшигч, захирал, ажилтан, өмгөөлөгч, агент, төлөөлөгч, гэрээлэгчид тус тус хариуцлага хүлээхгүй. ✓ Монгол НФТ сайтад байршуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хадгалах хэдий ч агуулгын таарамж, үнэн зөв, найдвартай, бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийн агуулгаас шууд болон шууд бусаар үүдэн гарсан аливаа хохирлыг хариуцахгүй болно. ✓ Бүтээл гаргагчийн амласан амлалт биелэгдсэн тохиолдолд хоёрдогч зах зээл дээр арилжаагдсан НФТ-ний амлалтын биелэлтэнд Монгол НФТ хариуцлага хүлээхгүй. ✓ Монгол НФТ нь бүтээл гаргагч, арилжаа эрхлэгчдэд ямар нэгэн зөвлөгөө өгөхгүй, тус мэдээллийн сайтад байршуулсан бүтээл, материалын өмнө хариуцлага хүлээхгүй. ✓ Монгол НФТ-ийн хаяг эзэмшигч болсноор та энэхүү гэрээний нэг тал болох бөгөөд 18 насанд хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай хувь хүн байх нь зүйтэй. Хэрэв та дээрх шаардлагыг хангахгүй бол таны асран хамгаалагч, харгалзан дэмжигч таны үйл ажиллагаанаас үүсэх хариуцлагыг хүлээх бөгөөд Монгол НФТ нь таны бүртгэлийг цуцлах, та болон асран хамгаалагчаас нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй болно.
24. НӨХӨН ТӨЛБӨР	✓ Та энэхүү үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, үйлчилгээ авснаар хэрэв зөрчил гаргасан тохиолдолд үүдэн гарах бүх хохирлыг (үүнд өмгөөлөгчийн хөлс болон эрх

		бүхий байгууллагаас ногдуулсан торгууль, шийтгэл багтана) арилгах үүрэг хүлээх бөгөөд Монгол НФТ, түүний салбар компаниуд, гэрээлэгчид, лиценз олгогчид, тэдний захирлууд, ажилтнууд, агентуудыг хохиролгүй байлгана гэдгийг хүлээн зөвшөөрнө. Энэ нь та Монгол НФТ-ийн үйлчилгээг ашиглах явцдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон гуравдагч этгээдийн эрхийг зөрчсөн тохиолдолд мөн хамаарна.
25. ЗАРЛАЛ	✓	Бүх албан ёсны зарлал, мэдээ, урамшуулал зэргийг Монгол НФТ-ийн олон нийтийн сүлжээ болон бүртгэлтэй цахим шуудангаар мэдээлнэ.
	✓	Харилцагч нь зарлал мэдээллийг үл хайхарсны улмаас түүнд учирсан алдагдал, хохиролд Монгол НФТ ямар ч хэлбэрээр хариуцлага хүлээхгүй.
26. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛИЙГ ЦУЦЛАХ	✓	Хэрэв Харилцагч та үйлчилгээний нөхцөл, нууцлалын бодлого, мөнгө угаахын эсрэг болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодлого болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн үйлдэл илэрсэн тохиолдолд нэн даруй тухайн Харилцагчийн Монгол НФТ хаягийг идэвхгүй төлөвт шилжүүлж, хандах эрхийг хязгаарлах арга хэмжээ авах ба хэтэвч үлдэгдэлтэй нөхцөлд хэтэвчийг царцааж, эрх бүхий байгууллагад мэдээллэх эрхтэй гэдгийг та хүлээн зөвшөөрнө. ✓ Монгол НФТ хэтэвчний гүйлгээний мэдээлэл болон холбогдох бусад мэдээллийг хадгалах, ашиглах бөгөөд эрх бүхий этгээдийн шаардсанаар гуравдагч этгээдэд дамжуулах, гаргаж өгөх эрхтэй байна. Хэтэвчний хяналтыг дараах тохиолдолд хэрэглэж болно. Үүнд : 1. Гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа болон бусад хүлээгдэж буй шүүн таслах ажиллагаанд тухайн хэтэвчний мэдээлэл хамаарах; 2. Виртуал хөрөнгө болон хэтэвчний хэвийн бус үйлдлийг илрүүлэх 3. Харилцагчийн хаягт зөвшөөрөлгүйгээр нэвтэрснийг илрүүлэх; 4. Шүүгчийн захирамж болон төрийн эрх бүхий байгууллагын тушаалаар. ✓ Дараах тохиолдолд Монгол НФТ нь үйлчилгээг шууд цуцалж, Харилцагчийн хаягийг хүчингүй болгох, нэвтрэх эрхийг цуцлах эрхтэй байна. Үүнд: 1. Харилцагчийн хүсэлтийн дагуу; 2. Өөр этгээдийн нэрээр бүртгүүлж Монгол НФТ-ийн Харилцагч болохыг шууд болон шууд бусаар удаа дараа оролдох; 3. Харилцагчийн иргэний үнэмлэхийн хүчин төгөлдөр төгөлдөр хугацаа дууссан бөгөөд шинэчилсэн иргэний үнэмлэхийг шаардсан хугацаанд ирүүлээгүй; 4. Харилцагч мэдээллээ шинэчлэх үүргийн хүрээнд мэдээлэл гарган өгөхөөс татгалзсан;

		5. Харилцагчийн өгсөн мэдээлэл хуурамч, алдаатай, хуучирсан, бүрэн бус байх; 6. Энэхүү гэрээ, дүрэм, журам шинэчлэгдсэн тохиолдолд Харилцагч үйлчилгээний шинэ гэрээг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлсэн; 7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байх магадлалтай (сөрөг мэдээлэл илэрсэн); 8. Олон улсын болон дотоодын хориг арга хэмжээний жагсаалтад бүртгэлтэй; 9. Авлига, хээл хахууль, залилан хийсэн талаарх мэдээлэл баталгаажуулсан; 10. Бусдын оюуны өмчид халдах, дуурайлган бүтээх, тэдгээрээр ашиг олох; 11. Бүтээлийг хууль бусаар, бүтээл гаргагчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, барааны тэмдэгт болгон ашиглах; 12. Бусад Харилцагчийг төөрөгдөлд оруулахаар нөхцөл байдлаар бүтээл гаргагчийн нэр, бүтээлтэй адил төсөөтэй бүтээл хийх; 13. Монгол НФТ нь үйлчилгээг цуцлах шаардлагатай гэж үзэх бусад нөхцөл байдал.
27. ХЭТЭВЧ ХААСНЫ ДАРААХ ҮЛДСЭН ХӨРӨНГӨ (ЭНГИЙН)	✓	Хэтэвч хаасны дараа хэтэвч дах үлдэгдэл Монгол НФТ-д төлөх ёстой өр төлбөрийг (хэрэв байгаа бол) үл маргах журмаар суутгаж авахыг Харилцагч нь үүгээр зөвшөөрсөн болно. Харилцагч хэтэвчнээс бүх хөрөнгөө гаргаж авахад ажлын 5 өдрийн хугацаа олгоно.
28. ХЭТЭВЧ ХААСНЫ ДАРААХ ҮЛДСЭН ХӨРӨНГӨ (ЛУЙВАР, МӨНГӨ УГААХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ЗӨРЧИЛ)	✓	Луйвар, мөнгө угаах хэргүүдийг мөрдөн шалгах, үйлчилгээний нөхцөлийг зөрчсөний (жишээ нь хориотой улсаас арилжаа хийгдэх) улмаас хэтэвчийг хаах тохиолдолд бид хэтэвч дэх хөрөнгийг битүүмжилж, Харилцагчийн мэдээллийг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.
29. ДОТООД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ДАГАЖ МӨРДӨХ	✓ ✓ ✓	Харилцагч нь Монгол НФТ үйлчилгээг ашиглахдаа тухайн орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Татвар төлөх, суутгах, тайлагнах зэрэг асуудлыг орон нутгийнхаа хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Монгол НФТ үйлчилгээний бүх Харилцагчид нь өөрсдийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль ёсны гэдгийг буюу хууль бус үйл ажиллагаанаас олоогүй гэдгээ хүлээн зөвшөөрнө. Монгол НФТ нь дэлхий даяар хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, мөрдөн шалгагдаж буй Харилцагчдын хэтэвч, хөрөнгийг хааж, цуцлах болно.
30. НУУЦЛАЛЫН БОДЛОГО	✓	Монгол НФТ нь Нууцлалын бодлого болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг платформдоо байршуулж, тухай бүрд нь Харилцагчдад мэдээлэх болно. Нууцлалын бодлого нь энэхүү үйлчилгээний нөхцөлийн салшгүй нэг хэсэг байна.
31. НӨХӨН ТӨЛБӨР БА ХОХИРЛЫГ	✓	Энэхүү нөхцөлийг зөрчсөн Монгол НФТ-ийн зөрчлөөс бусад тохиолдолд Харилцагч та Монгол НФТ болон түүний салбар

АРИЛГАХГҮЙ БАЙХ	компаниудын эсрэг аливаа гуравдагч этгээдийн гаргасан бүх зарга мэдүүлэг, нэхэмжлэлийг хариуцаж, Монгол НФТ болон түүний салбар компаниудыг хохиролгүй байлгахыг зөвшөөрч байна. Үйлчилгээний тухай тайлбарласны дагуу Монгол НФТ нь өөрийн веб сайт дээрх мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хадгалахын төлөө хичээн ажиллах ба платформ дахь мэдээлэл болон үйлчилгээнд баталгаа гаргахгүй. Монгол НФТ үйлчилгээг ашиглахаас үүдэн гарах алдаа дутагдалд хариуцлага хүлээхгүй. ✓ Энэхүү гэрээний дагуу хийгдсэн аливаа арилжааны үйлчилгээ, хөгжүүлэгч материал, болон гэрээгээр олгосон бусад зүйлстэй холбоотойгоор үүссэн аливаа санамсаргүй, шууд бус, онцгой, үр дагаварт хүргэх хохиролд (мэдээлэл, өгөх, ашиглах, алдагдах, ашиг, орлого, бизнесийн болон санхүүгийн бусад ашгийн алдагдлаас үүдсэн хохирол багтана) ямар ч тохиолдолд Монгол НФТ, түүний салбар компаниуд, тэдний хувьцаа эзэмшигчид, гишүүд, захирлууд, ажилтнууд, өмгөөлөгчид, агентууд, төлөөлөгчид, ханган нийлүүлэгч, гэрээлэгчид хариуцлага хүлээхгүй.
32. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ	✓ Монгол НФТ нь байгалийн гамшигт үзэгдэл, цаг агаарын онцгой нөхцөл байдал, гэнэтийн хүчин зүйлс, гал түймэр, дайн, бослого, үймээн самуун, хөдөлмөрийн маргаан, осол, засгийн газрын үйл ажиллагаа, харилцаа холбоо болон цахилгаан тасрах, тоног төхөөрөмж болон программ хангамж эвдрэх, хакер халдлага зэрэг хяналтаас гадуурх аливаа нөхцөл байдал, үйл явдлын улмаас учирсан аливаа хохирол, үйлчилгээний сааталд хариуцлага хүлээхгүй.
33. САНАЛ ХҮСЭЛТ	✓ Хэрэв танд манай үйлчилгээтэй холбоотой, санал, гомдол, хүсэлт болон асуулт байвал дараах хаягуудаар холбогдох боломжтой. • MongolNFT - Дискорд хаяг • support@mongolnft.com

Монгол НФТ платформын шимтгэл нь дараах төрөл, хувь хэмжээтэй байна. Үүнд:

Шимтгэл хураамжийн төрөл	Шимтгэл хураамжийн хувь, хэмжээ	
	НФТ худалдаж буй тал /зарах/	НФТ худалдан авч буй тал /авах/
Шимтгэл хураамж 1: Арилжааны Шимтгэл	MNFT койноор хийгдэж буй арилжааны нийт дүнгийн 10%-тай тэнцэх MNFT койноор шимтгэл төлнө.	The Wolves болон The Marals НФТ цуглуулга эзэмшигч нь MNFT койн эсхүл Төгрөгийн хослолоор хийж буй арилжааны нийт дүнгээс дараах хувьтай тэнцэх MNFT койны буцаан олголтын урамшууллыг тухай бүр хүлээн авна. Үүнд: 1. Алтан хонишоортой The Wolves НФТ эзэмшигч: 3% 2. Yellowish legendary (Deer), Black Legendary (Deer), Punk Black Lightning (Horn), Hybrid Lightning (Horn) шинэ чанартай The Marals НФТ эзэмшигч: 2% ** 3. Энгийн хэв шинжтэй The Wolves болон The Marals НФТ-ыг нэг, нэг буюу хоёрыг эзэмшигч: 1% ** *Энгийн хэв шинжтэй The Wolves эсхүл The Marals НФТ-ны аль нэгийг эзэмшиж буй харилцагчдад дээрх буцаан олголтын урамшуулал хамаарахгүй болно. ** Марал НФТ-тэй холбоотой буцаан олголт нь 2024 оны 3 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэнэ.
	Төгрөгийн хослолоор хийж буй арилжааны нийт мөнгөн дүнгийн 20%-тай тэнцэх төгрөгийн шимтгэл төлнө.	
Шимтгэл хураамж 2: Зарлагын гүйлгээний шимтгэл	Харилцагч төгрөгийн зарлага гаргах үед мөнгөн дүнгийн 1%-ийн гүйлгээний шимтгэл төлнө.	
Шимтгэлийн хураамж 3: Шилжүүлгийн шимтгэл	Хүлээн авагч буюу шилжүүлэх бирж, байгууллагаас хамааран харилцан адилгүй байх ба Харилцагч гүйлгээ хийх бүрд шимтгэлийн хувь хэмжээг гүйлгээний талбар хэсэгт харуулна. Харилцагч гүйлгээний шимтгэлийн нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр гүйлгээ буюу шилжүүлэг хийх боломжтой.	
Шимтгэл хураамж 4: Ногдол ашгийн шимтгэл	Идэш хөтөлбөрөөс ногдол ашиг хэлбэрээр хүлээн авч буй Төгрөг, MNFT койн, Stable койн болон бусад койн, токеноос 10% хүртэл шимтгэл төлнө.	